



Оюу Толгой ХХК

Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчны
Удирдлагын тогтолцооны журам

3-р хэсэг. Аюул, эрсдлийн менежмент

Аюулыг таних, эрсдлийн менежмент		
Хүчин төгөлдөр болох огноо: 2012.11.20	Баримт бичгийн дугаар: ОТ-03-PRC-0001-М	Хувилбар: 2.1

1. ЗОРИЛГО

ЭМААБО-ны бүх аюул, асуудал, боломжуудыг нийтлэг аргаар тодорхойлох, үнэлэх, бүртгэх, мэдээлэх мөн:

- Тэдгээрийн хүн, эд зүйлс, өмч хөрөнгө, байгаль орчинд учруулах эрсдлийг үнэлсэн эсэх
- Эрсдэлд менежмент хийхдээ тэдгээрийг боломжит хамгийн бодитой бага түвшинд (ALARP) байлгахын тулд хяналтын шаталсан арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа эсэх
- ЭМААБО-ны эрсдлийг бууруулахын тулд зохих хууль, дүрэм, журмыг сахиж, тэдгээрийн шаардлагыг хангаж байгаа эсэх
- Мэдээллийг нэгдсэн бүртгэлд оруулсан эсэхийг магадлах

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэ журмыг Оюу Толгой ХХК (ОТ)-ийн бүх үйл ажиллагааны хүрээнд, мөн төслийн талбайн ажилтнууд, гэрээт байгууллагууд дагаж мөрдөнө. Оюу Толгой ХХК-ийн үйл ажиллагаа, төслийн талбайд ЭМААБО-ны удирдлагын тогтолцооны стандарт, холбогдох журмуудыг дагаж мөрдөнө.

3. АБАН ТУШААЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Ажил үүрэг	Үүрэг хариуцлага
Эрсдэл хариуцсан ажилтан, сценарь хариуцсан ажилтан	<ul style="list-style-type: none"> • Эрсдлийн дүр зургийг нягтлан үзэж, батлах, хяналтын арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих
Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчийн ажиллагсад, зочид	<ul style="list-style-type: none"> • Ажил гүйцэтгэж байгаа ажилтнууд энэ стандарт/журмыг бүрэн дагаж мөрдөнө. • Бүх ажилтнууд энэ журмын дагуу аюулыг таних, ажлаа хянах үүрэгтэй.
Ахлах ажилтнууд	<ul style="list-style-type: none"> • Эрсдлийн үнэлгээний семинар, хэлэлцүүлэгт оролцох • Өөрсдийн хариуцсан ажлын талбарт шаардлагатай хяналтын арга хэмжээ хэрэгжүүлэх, хяналт тавих • Аюул, түүний хяналтын талаар багийнхантайгаа ярилцах
Сургалтын хэлтэс	<ul style="list-style-type: none"> • Шаардлагатай сургалт, хичээлүүдийг зохион байгуулах • Сургалтын төлөвлөгөө гаргах, оролцогчдын ирцийн бүртгэл, сургалтын материалын бүртгэл хөтлөх
Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, байгаль орчин болон орон нутгийн харилцаа харицусан баг	<ul style="list-style-type: none"> • Эрсдлийн үнэлгээ зохион байгуулах, зохицуулах • Эрсдлийн үнэлгээ, авах арга хэмжээний төлөвлөгөөнд хяналт тавих, тайлагнах • Ажлын багуудтай эрсдлийн бүртгэлийг хянан үзэх ээлжит уулзалтуудыг зохион байгуулах (хамгийн багадаа жилд нэг удаа)
ЭМААБО-ны эрсдэл,	<ul style="list-style-type: none"> • ЭМААБООН-д учирч болзошгүй аюулын бүртгэл

Аюулыг таних, эрсдлийн менежмент		
Хүчин төгөлдөр болох огноо: 2012.11.20	Баримт бичгийн дугаар: ОТ-03-PRC-0001-M	Хувилбар: 2.1

удирдлагын тогтолцооны баг	боловсруулах ажлыг зохион байгуулах • Гадаад талуудад болон компанийн ахлах удирдлагад зориулсан тайлан бэлтгэх • Хяналт дүгнэлт, авах арга хэмжээний төлөвлөгөөнд хяналт тавих
----------------------------	---

4. ЖУРАМ

4.1. Аюул, эрсдэлд менежмент хийх үйл явц, тогтолцоо

Оюу Толгойн үйл ажиллагаанд, үүний дотор төлөвлөгөөт, шинэ, эсвэл сайжруулсан бүтээн байгуулалт, үйл ажиллагаа зэрэг бүх үйл ажиллагаанд ЭМААБО-ны эрсдлийн менежмент хийхдээ Рио Тинтогийн Ажлын Мөчлөг: Аюулыг таних, эрсдлийн менежмент хийх журам (WCMS0301) болон аюулыг таних, тайлагнах журмыг (WCMS0302) дагаж мөрдөнө.

Тодорхойлж танисан аюулын нөхцөл байдал, шинж чанар, эрсдлийн түвшинөөс нь хамааруулан эрсдлийн үнэлгээ хийнэ. Дараах үнэлгээний арга хэрэгслүүдийг ашиглана.

- 1-р түвшин – Ажлын өмнөх аюулын үнэлгээ (ажлын даалгавар/үйл явцад тулгуурласан)
 - УХААН үнэлгээ
 - Ажлын аюулын дүн шинжилгээ (ААДШ)

Ажлын өмнөх аюул эрсдлийн үнэлгээ (1-р түвшин) гэдэг нь бүх ажилтнууд аливаа ажил үүрэг гүйцэтгэхийн өмнө ганцаараа эсвэл багаараа өдөр тутмын ажлынхаа салшгүй хэсэг болгон хийх **шаардлагатай**, ажлын даалгаварт үндэслэсэн эрсдлийн үнэлгээ юм.

- 2-р түвшин – Чанарын аргаар эрсдлийг үнэлэх арга

5x5 эрсдлийн матриц (ОТ-03-COM-0009/10-E-ЭМААБО-ны эрсдлийн матриц А4/Халаасны карт) ашиглан тухайн ажлын талбарын эрсдэл, ижил төрлийн нөлөөллийн бүлгийн (ИТНБ) эрсдлийг тодорхойлдог чанарын аргаар эрсдлийг үнэлэх үнэлгээг (2-р түвшин) ажлын талбар болгонд хийж, эрсдлийн нэгдсэн бүртгэлд бүртгэж баримтжуулна. Ажлын талбаруудын аюул, авах арга хэмжээ нь ижил тохиолдолд тус тусад нь ангилалгүй, нэг бүлэгт хамруулж авч үзнэ.

- 3-р түвшин – Тоон аргаар эрсдлийг үнэлэх арга

- Хагас чанарын аргаар эрсдлийг үнэлэх үнэлгээ (SQRA)
- Аюулын товч лавлагаа
- Үйл ажиллагааны аюулгүй ажиллагааны хяналт, үнэлгээ
- Дотор нь хүн байгаа байгууламжийн эрсдлийн үнэлгээ

3-р түвшинд эрсдлийг үнэлэхэд ахисан түвшний үнэлгээний арга хэрэгсэл (математик загварчлал зэрэг), нарийн мэдлэг мэргэжил шаардана. Чанарын аргын эрсдлийн үнэлгээгээр (2-р түвшин) “маш их” (IV ангилал) үр дагавартай гэж үнэлэгдсэн эрсдэлд эдгээр тоон үнэлгээг хийх шаардлагатай.

Дэлгэрэнгүй мэдээллийг Рио Тинтогийн ЭМААБО ЧУС 3-р хэсэг болох Аюулыг таних, эрсдлийг үнэлэх зааварчилгаа болон Рио Тинто ажлын мөчлөг: Аюулыг таних, эрсдлийн менежмент хийх (WCMS0301) баримт бичгүүдээс авна уу.

Чанарын аргаар эрсдлийг үнэлэх (2-р түвшин), тоон аргаар эрсдлийг үнэлэх үнэлгээгээр (түвшин 3) тодорхойлсон бүх эрсдлийг тухайн эрсдэл хариуцсан ажилтан **баталж**, их (III

Аюулыг таних, эрсдлийн менежмент		
Хүчин төгөлдөр болох огноо: 2012.11.20	Баримт бичгийн дугаар: ОТ-03-PRC-0001-М	Хувилбар: 2.1

ангилал), маш их (IV ангилал) ангилалд орсон эрсдлүүдийг жилд хамгийн багадаа нэг удаа, бусад бүх эрсдлийг гурван жилд нэг удаа хянан хэлэлцэж, шинэчилж байх шаардлагатай.

Эрсдлийн үнэлгээний талаарх мэдээллийг нэгтгэж, холбогдох ажилтнуудад мэдээлэх **ёстой** ба ингэснээр ажилтнууд өөрсдийн ажлын талбар, ижил төрлийн нөлөөллийн бүлэг, эрсдлийг удирдахад ашиглах арга хэмжээний талаар мэдээлэлтэй болно.

Эрсдлээс зохих түвшинд хамгаалахын тулд эрсдлийн хяналтын арга хэмжээг тогтмол зохион байгуулж, хяналт тавьж, үзлэг шалгалт хийх **шаардлагатай**. Хяналтын арга хэмжээний шаталсан системийг ашиглан хамгийн эхэнд авч үзсэн хяналтын арга хэмжээг хасах журмаар тохирсон хяналтын арга хэмжээг тодорхойлно. Эрсдлийн үнэлгээ хийхдээ уг эрсдлийг хянах арга хэмжээг тодорхойлж, хяналтын арга хэмжээний үр ашигтай байдлыг үнэлнэ. Эрсдлийн хяналтын арга хэмжээний үнэлгээг Рио Тинто Бизнес Шийдэл (РТБШ) дээр эрсдлийн хариу авах арга хэмжээг удирдан явуулах систем ашиглан хийнэ.

4.2. Эрсдлийн үнэлгээ хийх

4.2.1. 1-р түвшин. Ажлын өмнөх аюулын үнэлгээ

УХААН үнэлгээ: Аливаа ажил үүрэг гүйцэтгэхийн өмнө бүх ажилтнууд тухайн ажлын аюулыг тодорхойлох, зохих хяналтын арга хэмжээг тодорхойлох зорилгоор УХААН үнэлгээ (ажлын өмнөх аюулын үнэлгээ) хийх ёстой. Аюул, асуудал, боломжийг хянах боломжгүй нь тогтоогдсон тохиолдолд багаараа эрсдлийн үнэлгээ хийнэ. (ОТ-03-PRC-0003-М Ажлын өмнөх аюул эрсдлийн үнэлгээ (УХААН) хийх журмыг харна уу).

ААДШ: ажлын өмнөх аюулын албан ёсны, цогц үнэлгээг ажлын хэсгээрээ эсвэл цөөн хүний бүрэлдэхүүнтэй багаараа хийнэ. ААДШ-нд тухайн үйл ажиллагаанд хийгдэх алхмуудыг зохион байгуулалттайгаар шинжлэн дүгнэж, алхам нэг бүрийн аюулыг тодорхойлон, болзошгүй нөлөөллийг үнэлж, эрсдлийг бууруулах хяналтын арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх талаар авч үздэг. ААДШ хийх болгондоо Ажлын аюулын дүн шинжилгээний (ААДШ) загварыг (ОТ-03-TMP-0013-М) ашиглана. (Ажлын өмнөх аюулын үнэлгээ ААДШ-ний журмыг харна уу (ОТ-03-PRC-0005-М)). Тухайн ажлын АСЖ байгаа бол ААДШ хийх шаардлагагүй.

4.2.2. 2-р түвшин. Чанарын аргаар эрсдлийг үнэлэх арга

Дараах үйл ажиллагаануудын аюулыг тодорхойлж, эрсдлийг үнэлэн, зохих ёсоор хяналтын арга хэмжээ авч, эрсдлийг шинжлэн шалгах хэрэгтэй:

- Ажлын үүрэг даалгавар
- Ажлын арга технологи
- Арга технологи, баримт бичигт орсон өөрчлөлт (ОТ-11-PRC-0001-М-Өөрчлөлтийн менежментийн журмыг харах).
- Журам, ажлын аргазүйд орсон өөрчлөлт
- Хууль тогтоомж, бусад үүрэг амлалтад орсон өөрчлөлт
- Ложистик, гэрээт байгуулагын үйл ажиллагаа
- Төсөл

Эрсдлийн үнэлгээнд (тусгайлан бэлтгэгдсэн мэргэжилтэнээр хийлгэх) ЭМААБО-ны эрсдлийн чанарын үнэлгээний (5x5) матрицад тодорхойлсон ЭМААБО-ны нийгэм, байгаль орчинд үзүүлэх бүх төрлийн нөлөөллийг авч үзнэ. Тэдгээр нь дараах болно:

Аюулыг таних, эрсдлийн менежмент		
Хүчин төгөлдөр болох огноо: 2012.11.20	Баримт бичгийн дугаар: ОТ-03-PRC-0001-M	Хувилбар: 2.1

- Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл
- Хувь хүний аюулгүй байдалд үзүүлэх нөлөөлөл
- Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл
- Орон нутагт үзүүлэх нөлөөлөл
- Дүрэм журмын мөрдөлтөд үзүүлэх нөлөөлөл
- Бизнесийн нэр хүндэд үзүүлэх нөлөөлөл

ОТ-д өнөөгийн эрсдэл нь бага, дунд, их түвшинд хамаарагдаж буй үйл ажиллагааг үргэлжлүүлэхийг хүлээн зөвшөөрнө. Харин өнөөгийн эрсдлийн түвшин нь маш их түвшинд байгаа үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд ийм түвшний эрсдэлтэй гэж тодорхойлсон тохиолдолд тухайн ажлын талбар ажлыг үргэлжлүүлэхийн тулд Ерөнхий менежер, Үйл ажиллагаа хариуцсан ерөнхий менежерийн зөвшөөрөл авах шаардлагатай.

2-р түвшний эрсдлийн бүртгэлийн загварыг (ОТ-03-TMP-0015-E- 2-р түвшний эрсдлийн үнэлгээний загвар) дараах зорилгоор ашиглана,

- хэсэг бүрээс ажилтнуудын төлөөлөлтухайлбал аюулд өртөж болзошгүй ажилтнуудыг эрсдлийн бүртгэлийг боловсруулахад оролцуулах
- эрсдлийг бууруулах арга хэмжээг хэлэлцэж, авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах,
- хяналтын арга хэмжээг тодорхойлоход хяналтын арга хэмжээний шаталсан систем ашиглах гэх мэт.

4.2.2.1. Эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийн үнэлгээ, ижил төрлийн нөлөөллийн бүлэг (ИТНБ)

ОТ-н эрүүл мэнд хариуцсан баг ажил мэргэжлээс шалтгаалах эрүүл мэндийн аюул эрсдэлд өртөх магадлалтай ижил төрлийн нөлөөллийн бүлгийг (ИТНБ) тодорхойлох ажлыг хариуцна.

Ижил төрлийн нөлөөллийн бүлгийг (ИТНБ) ажил мэргэжлээс шалтгаалах болзошгүй аюул эрсдлээр нь тогтооно. ИТНБ-ийг тогтоох үндсэн хүчин зүйлсэд доорх зүйлс хамрагдах ба эдгээрээр хязгаарлагдахгүй:

- Ажлын даалгавар/ ажлын арга технологи
- Ажил/арга технологийн давтамж мөн/эсвэл үргэлжлэх хугацаа
- Орчны хүчин зүйлс
- Ажлын ангилал (тодорхойлолт)

Өнөөгийн байдлаар явагдаж буй ажлуудын ижил төрлийн нөлөөллийн бүлгийн (ИТНБ) эрсдлийн үнэлгээ хийж, хяналтын арга хэмжээг тодорхойлон ОТ эрүүл мэндийн эрсдлийн бүртгэлд бүртгэж хадгална.

Мэдэгдсэн болон хорт хавдар үүсгэх, нөхөн үржихүйн үйл явцад нөлөөлж болзошгүй бусад үүсгэгч хорт бодисын нөлөөнд өртсөн тохиолдолд ОТ-н Эрүүл мэнд хариуцсан баг эрсдлийг боломжит хамгийн бага түвшинд (ALARP) барихын тулд жил бүр эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ хийлгүүлнэ.

4.2.3. 3-р түвшин. Тоон аргаар эрсдлийг үнэлэх арга

3-р түвшний эрсдлийн үнэлгээг тусгайлан бэлтгэгдсэн мэргэжилтэн хийнэ.

Аюулыг таних, эрсдлийн менежмент		
Хүчин төгөлдөр болох огноо: 2012.11.20	Баримт бичгийн дугаар: ОТ-03-PRC-0001-M	Хувилбар: 2.1

2-р түвшний чанарын үнэлгээгээр “маш их” ангилалд орсон эрсдлүүдэд 3-р түвшний эрсдлийн үнэлгээ нэмж хийнэ. 3-р түвшний үнэлгээг (SQRA- хялбаршуулсан тоон аргаар эрсдлийг үнэлэх үнэлгээ хамаарна) мөн дараах шалтгааныг үндэслэн хийж болох боловч эдгээр шалтгаанаар хязгаарлагдахгүй. Үүнд:

- чанарын аргаар эрсдлийг үнэлсэний дараа эрсдэл бүхий тодорхойгүй байдал өндөр түвшинд хэвээр байх,
- хууль тогтоомжийн шаардлагад заасан бол, тухайн эрсдэл нь “их” ангилалд орж “онц ноцтой”, “гамшгийн” үр дагавар дагуулах ангилалд орсон бол,
- хөндлөнгийн аудит хяналт, удирдлагын дүн шинжилгээгээр 3-р түвшний эрсдлийн үнэлгээ хийх зөвлөмж өгсөн бол,
- онц ач холбогдолтой төсөл, технологийн судалгаа бол,
- гол оролцогч талууд шаардлагатай гэж үзсэн бол эсвэл цогц өөрчлөлтөд менежмент хийх болсон зэрэг шалтгаанууд багтана.

4.3. Хяналт болон авах арга хэмжээний удирдлага

Аюул, ноцтой эрсдлүүдийг тодорхойлж, одоогоор үйлчилж буй хяналтын арга хэмжээ, нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай бол авах арга хэмжээний төлөвлөгөө гаргаснаар эрсдлийн үнэлгээ бүрэн хийгдсэн гэж үзнэ. Дараах хүснэгтэд эрсдлийн ангиллын дагуу авбал зохих хяналтын арга хэмжээг нарийвчлан тодорхойлсон.

Ангилал		ЭМААБО-ны эрсдлийг удирдах арга хэмжээ	Арга хэмжээ авах хугацаа
Маш их	IV ангилал	АБӨХ-ыг хол давсан эрсдэл бөгөөд нэн даруй анхаарал харуулах, шуурхай арга хэмжээ авах шаардлагатай.	<u>Шуурхай</u> арга хэмжээ авах шаардлагатай.
Их	III ангилал	АБӨХ-ыг давсан эрсдэл бөгөөд идэвхтэй арга хэмжээ авах шаардлагатай. Идэвхтэй арга хэмжээ авч хэрэгжүүлсэн боловч эрсдэл нь бодитой буураагүй эрсдэл орно. Идэвхтэй хяналт шаардлагатай бөгөөд тухайн үйл ажиллагааны нэгжийн ахлах удирдлагаар батлуулах шаардлагатай.	<u>Богино хугацаанд</u> арга хэмжээ авах шаардлагатай. Эрсдлийн түвшинг бууруулахын тулд сайжруулах зүйлсийг Жилийн Сайжруулалтын төлөвлөгөөнд оруулах шаардлагатай.

Дунд	II ангилал	АБӨХ-ын зааг дээр байх эрсдэл бөгөөд байнгын хяналт тавих шаардлагатай. Цаашид эрсдлийг бууруулах чиглэлээр нэмэлтээр хэмжилтийн арга хэмжээ авч	<u>Дундаж хугацаанд</u> арга хэмжээ авах шаардлагатай. Эрсдлийн түвшинг бууруулахын тулд сайжруулах зүйлсийг Жилийн
-------------	-------------------	--	---

Аюулыг таних, эрсдлийн менежмент		
Хүчин төгөлдөр болох огноо: 2012.11.20	Баримт бичгийн дугаар: ОТ-03-PRC-0001-M	Хувилбар: 2.1

		болно.	Сайжруулалтын төлөвлөгөөнд оруулах шаардлагатай.
Бага	I ангилал	АБӨХ-аас бага эрсдэл бөгөөд идэвхтэй арга хэмжээ авах шаардлагагүй. Зарим эрсдэлд нэмэлт хяналтын арга хэмжээ авах шаардлага гарч болно.	Тогтсон үйл явцын дагуу зохицуулалт хийнэ.

Хэрэгжүүлж буй бүх хяналтын арга хэмжээг хариуцсан ажилтан байх ба ЭМААБО-ны үйл ажиллагаануудаар (ажлын талбарын үзлэг шалгалт, Чухал хяналтын арга хэмжээний мониторингийн төлөвлөгөө гэх мэт) эдгээр хяналтын арга хэмжээнд мониторинг хийнэ. Төлөвлөсөн хяналтын арга хэмжээ эсвэлавах арга хэмжээний хэрэгжилтийг хариуцсан ажилтанг томилно. Хэрэгжүүлэх арга хэмжээг Рио Тинтогийн Бизнес Шийдэлд оруулж, авах арга хэмжээний удирдлагын журмын (ОТ-14-PRC-00009-E) дагуу хэрэгжүүлнэ.

ЭМААБО-ны өндөр эрсдэлтэй эрсдлүүдтэй холбоотой АСЖ, бусад ажлын зааварчилгааг баримтжуулж, тухайн аюул, хяналтын арга хэмжээний талаар ажлын багийнханд мэдээлэл авах боломжийг бүрдүүлж өгнө.

4.4. Хяналт, үнэлгээ

Тухайн талбар хариуцсан ЭМААБО-ны ахлах ажилтан эрсдлийн бүртгэлийг тогтмол хугацаанд дахин нягтлах ажлыг хариуцна. ЭМААБО-ны “их”, “маш их” түвшний эрсдэл хэмээн тодорхойлсон эрсдэлд жилд хамгийн багадаа нэг удаа дахин үнэлгээ хийх ёстой. Бусад эрсдлийн үнэлгээг ач холбогдол, хяналтын арга хэмжээний төрлөөс нь шалтгаалан гурван жилд нэг удаа дахин хийнэ. Үүнд: дунд зэргийн аюултай эрсдлийн үнэлгээг илүү ойр давтамжтай хийнэ. Ахлах ажилтнууд нь эрсдлийн үнэлгээний үе шатанд тодорхойлсон эсвэл тухайн эрсдлийн түвшингээс нь хамааран тогтоосон давтамжаар бусад эрсдлийн үнэлгээг зохицуулна. ЭМААБО-ны “их”, “маш их” түвшний эрсдлийг дахин үнэлэхээс гадна, ОТ, осол зөрчлийн дараа, аюул эрсдлийг тодорхойлмогц, ажлын арга технологи өөрчлөгдсөний дараа Рио Тинтогийн ЭМААБО-ны Гүйцэтгэлийн стандарт, аюултай холбоотой аюул эрсдлийн үнэлгээг тогтмол хугацаанд хийнэ.

Одоогийн эрсдлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлэх арга хэмжээ бүхий эрсдлийн үнэлгээнд бүх арга хэмжээг хэрэгжүүлж дуустал хянах болно. Арга хэмжээний хэрэгжилтийн явцын үнэлгээг Төслийн талбайн ЭМААБО-ны хороо, удирдлагын хурлаар авч хэлэлцэнэ. Эрсдлийн үнэлгээтэй холбоотой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлсний дараа одоогийн хэрэгжүүлж буй хяналтын арга хэмжээ, одоогийн тодорхойлсон эрсдэл зэргийг авч үзэн эрсдлийн үнэлгээг авч хэлэлцэнэ. Уг хэлэлцүүлэг хийх бүрэлдэхүүнд эрсдлийн үнэлгээнд анх оролцсон хүмүүс, ЭМААБО-ы ажилтнууд, тухайн салбарын мэргэжилтнүүд орно.

4.5. Мэдээлэх, тайлагнах

Бүх ноцтой аюул эрсдэл, тэдгээрийн хяналтын арга хэмжээг тодорхойлж, уг эрсдэлд өртөж болзошгүй бүх хүмүүст мэдээлнэ.

Эрсдлийн шинжилгээ, удирдлагын үр дүнг холбогдох бүх талуудад мэдээлснээр эрсдлийг таньж мэдэхэд нь тусална. Мэдээлэх, тайлагнах арга хэлбэрүүдэд: (ОТ-09-PRC-0001-Мэдээлэх, зөвлөмж өгөх журам)

Аюулыг таних, эрсдлийн менежмент		
Хүчин төгөлдөр болох огноо: 2012.11.20	Баримт бичгийн дугаар: ОТ-03-PRC-0001-M	Хувилбар: 2.1

- Ажлын өмнөх уулзалт
- Зурагт хуудас, мэдээллийн компани ажил
- Хороод
- Чанарын аргын эрсдлийн (2-р түвшин) төвлөрсөн бүртгэлд бүх эрсдэл хариуцсан ажилтнууд, компанийн холбогдох оролцогч талуудад хүртээмжтэй ашиглах боломжтой байх ёстой.
- Тоон аргын эрсдлийн үнэлгээ (3-р түвшин) хийсний дараах “маш их” ангиллын эрсдлийн талаар Рио Тинтогийн нийгэм, байгаль орчны талаар тайлагнах ажлын мөчлөгт (WCMS1401) заасны дагуу Группэд тайлагнана.

4.6. Баримт бичиг, бүртгэл

1-р түвшний үнэлгээ болох УХААН, ААДШ-г баримтжуулж, тухайн ажлын талбарт хадгална.

2-р түвшний эрсдлийн үнэлгээг 2-р түвшний эрсдлийн үнэлгээний бүртгэлийн загвар ашиглан тэмдэглэнэ. 2-р түвшний эрсдэл нь төслийн талбайд нийтэд нь хамааралтай эсвэл одоо учирч болзошгүй эрсдэл бол Рио Тинтогийн Бизнес Шийдэл дэх эрсдлийн бүртгэлд оруулна. 2-р түвшний эрсдлийн үнэлгээний эх хувийг баримт бичгийн хяналтад оруулан баримтжуулан хадгална.

3-р түвшний эрсдлийн үнэлгээ

- хялбаршуулсан тоон аргаар үнэлсэн эрсдлийг бүртгэж, эрсдлийн ерөнхий оноо, авах арга хэмжээний төлөвлөгөөг Рио Тинтогийн Бизнес Шийдлийн эрсдлийн бүртгэлд оруулна.
- Бусад: РТБШ-д бүртгэл ('аудит' хэлбэрээр) үүсгэснээр баримт бичгийг хавсаргах, ажлын үйл явцыг нэгдсэн арга механизмаар хянах боломжтой болно.

4.7. Сургалт

УХААН, ААДШ зэрэг эрсдлийн үнэлгээний сургалтад бүх үндсэн болоод, гэрээт байгууллагын ажилтнууд хамрагдах шаардлагатай. 2-р түвшин, 3-р түвшний эрсдлийн үнэлгээ хийх ажилтны сургалтад нэр заасан ажилтнууд хамрагдана. ЭМААБО-ны сургалт, үр чадвар, мэдээллийн журмаас (ОТ-06-HSE-0001-M) дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

5. ТОДОРХОЙЛОЛТ

ALARP (боломжит хамгийн бага түвшин): зардал, цаг хугацаа, нөөцийн хувьд цаашид үр дүнтэйгээр бууруулах боломжгүй, хүлээн зөвшөөрч болохоор хэмжээнд хүртэл буурсан, дааж гарч болохоор эрсдэл

Хяналтын арга хэмжээ: эрсдлийг бууруулахад чиглэсэн аливаа арга технологи, бодлого, арга хэрэгсэл, практик, бусад арга хэмжээ

Аюул: хүн, хүрээлэн буй орчин, барилга байгууламж, тоног төхөөрөмжид бодит хор хохирол учруулах боломжит нөхцөл, болзошгүй аюулын хор хохиролын эх үүсгүүр.

Аюулыг тодорхойлох: аюул заналыг (сөрөг үр дагавартай эрсдэл) тодорхойлох үйл явц мөн боломжийг (боломжит эерэг үр дагавартай эрсдэл) ашиглах арга хэмжээ тодорхойлох үйл явц

Аюулыг таних, эрсдлийн менежмент		
Хүчин төгөлдөр болох огноо: 2012.11.20	Баримт бичгийн дугаар: ОТ-03-PRC-0001-M	Хувилбар: 2.1

Эрсдэл: нэг түүнээс дээш зорилтод хүрэхэд нөлөө үзүүлэх тохиолдож болзошгүй тодорхойгүй үйл явдал, нөхцөлийг эрсдэл гэнэ. Эрсдлийг тохиолдох магадлал, болзошгүй үр дагаварт нь үндэслэн хэмжиж, ерөнхий эрсдлийн ангилалд хуваана.

SQRA: хагас чанарын аргаар эрсдлийг үнэлэх арга

АСЖ: Ажлын Стандарт Журам

Ноцтой эрсдэл: 'их' (III ангилал) эсвэл 'маш их' (IV ангилал) (Рио Тинтогийн тодорхойлолт) ангилалд орно гэж тодорхойлсон эрсдэл

6. ЛАВЛАГАА, ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГҮҮД

	Баримт бичгийн нэр	Байршил
Хууль эрхзүйн болон бусад шаардлагууд	Рио Тинтогийн ЭМААБОЧ Удирдлагын тогтолцооны стандарт 3-р хэсэг – Аюулыг таних, эрсдлийг удирдах	Прспект
	Рио Тинтогийн ЭМААБОЧ УТ-н стандартын зааварчилгаа 3-р хэсэг – Аюулыг таних, эрсдлийг удирдах	
	WCMS0301 Ажлын мөчлөг: Аюулыг таних, эрсдлийн менежмент	
	WCMS0302 Ажлын мөчлөг: Аюулыг таних, тайлагнах	
	Нэмэлт мэдээлэл, хэрэгслүүд <ul style="list-style-type: none"> Эрсдлийн үнэлгээний гарын авлага, аюул, нөлөөллийн төрөл Аюулгүй байдлын урьдчилсан үнэлгээ (өөрөө үнэлэх) хийх процесс, болзошгүй аюул, дотор нь хүнтэй барилга (жишээтэй) Эрсдлийн хяналт, авах хариу арга хэмжээний төлөвлөгөөний маягт 	
Оюу Толгой ЭМААБО-ны удирдлагын тогтолцоо	Баримт бичиг, баримт бичгийн хяналтын журам (ОТ-08-PRC-0001-M)	ОТ Цахим хуудас
	Авах арга хэмжээний удирдлагын журам (ОТ-14-PRC-0009-M)	
	Ажлын өмнөх аюулын үнэлгээ ААДШ хийх журам (ОТ-03-PRC-0005-M)	
	Ажлын өмнөх аюул эрсдлийн үнэлгээ УХААН хийх журам (ОТ-03-PRC-0003-M)	
Маягт, Шалгах хуудас, Зөвшөөрөл, загвар	2-р түвшний эрсдлийн үнэлгээний уулзалтын тэмдэглэл хөтлөх загвар (ОТ-03-TMP-0015-M)	ОТ Цахим хуудас
	УХААН үнэлгээний тохирлын картын загвар (ОТ-03-TMP-0001-M)	
	Ажлын аюулын дүн шинжилгээний (ААДШ) загвар (ОТ-03-TMP-0013-M)	

Аюулыг таних, эрсдлийн менежмент		
Хүчин төгөлдөр болох огноо: 2012.11.20	Баримт бичгийн дугаар: ОТ-03-PRC-0001-M	Хувилбар: 2.1

Бүртгэл	Эрсдлийн бүртгэл (ОТ-н эрсдлийн үнэлгээний жагсаалтыг харах)	Excel eRoom RTBS
	Авах арга хэмжээний төлөвлөгөө	
Мэдээлэл/Сургалт	Рио Тинтогийн 2-р түвшний эрсдлийн үнэлгээ хийх ажилтны сургалт (4 модуль)	ОТ Цахим хуудас
	ЭМААБО эрсдлийн матриц А4 (ОТ-03-COM-0009-M)	
	ЭМААБО эрсдлийн матриц карт (ОТ-03-COM-0010-M)	

7. БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ

Баримт бичгийн нэр	ОТ-03-PRC-M-0001-Hazard and Risk Management Procedure
Тодорхойлолт	ЭМААБО Аюул, эрсдлийн менежментийн журам
Эх зохиогч	М.ДеАлтерио
Боловсруулсан огноо	2012.11.01
Баталсан	Марк Слэйтр, ЭМААБО-ны Ерөнхий менежер
Баталсан огноо	2012.11.20
Өөрчлөлт хийсэн бүртгэлийн дугаар	##

Эрсдлийн ангилал	Үнэлгээ хийсэн огноо	Эрсдлийн үнэлгээ хийсэн	Засвар өөрчлөлт хийх хуваарь	Дараагийн хэлэлцэх хугацаа
Их	2012.10.20	М.ДеАлтерио	2 жилд нэг удаа	Эхний: 2013.03.20 Дараагийн: 2014.06.03

Хувилбар	Хувилбарын огноо	Эх зохиогч	Баталсан	Засвар өөрчлөлтийн талаарх тэмдэглэл
1.0	2012.11.20	М.ДеАлтерио	Марк Слэйтр	Баталсан – 3 сарын дотор хянан хэлэлцэх шаардлагатай.
2.0	2013.01.18	Б. Долгор	М.ДеАлтерио	Дараах хэсгүүдийг өөрчилсөн: <ul style="list-style-type: none"> 4.2.3 4.4 'ноцтой' гэснийг 'их, маш их' гэж сольсон 5: тодорхойлолтуудыг шинэчилсэн Формат бага зэрэг өөрчилсөн
2.1	2013.06.03	Б. Долгор	М.ДеАлтерио	Баримт бичгийн хяналт хийж, монгол хэлний орчуулгыг хянав.